

СЭТГЭЛ ХӨДЛӨЛ ИЛЭРХИЙЛСЭН ҮГ ХЭЛЛЭГ, ТЭДГЭЭРИЙГ ОРЧУУЛАХ ТУХАЙД

С.Булгантамир³⁵

Abstract: *This paper analyses the challenges of translating words and expressions that express emotion within the context of a selected novels. In the first part, we discuss how emotion is expressed through Mongolian and French language, exploring different theories of emotion and outlining what exactly is defined as an “emotion word and expression”. It argues that there are often multiple possible translations. The role of words or expressions denoting different types of emotions in reproducing the emotional charge of a literary text in translation, the necessity to preserve the signification and impact of such words in the text and choice of positive and negative emotion words and expressions are discussed. We come to the conclusion that the translation deviation from the original is predetermined by the difference in the ways emotions are expressed and such words are used by different cultures and literary traditions.*

Түлхүүр үг: *сэтгэл хөдлөл, үг хэллэг, орчуулга, хэл, соёл (emotion, words and expressions, translation, language, culture)*

Уран зохиолын эхийг амилуулж, түүний чухал хэсгийг бүрдүүлж байдаг зүйл бол дүрүүдийн сэтгэл хөдлөлийн бодитой, уран яруу дүрслэл юм. Тийм ч учраас, аливаа хэлнээс ямар нэгэн уран зохиолын эх орчуулахдаа үүнийг чухалчлан авч үзэх нь зөв бөгөөд дүрүүдийн сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг хэллэгүүдийг зөв буулган, дүйцүүлэх нь нэн чухал билээ. Тиймээс тухайлан баярлах, гуних сэтгэл хөдлөлийг, монгол, франц өгүүллийн франц, монгол орчуулгыг ажиглаж, орчуулгын онолд үндэслэн судалж, сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг хэллэгийг (нэр үг, үйл үг, тэмдэг нэр, хэлц үг) үгийн сангийн түвшинд орчуулахад анхаарах онол, арга зүй, шинэ санаа эрэлхийллээ.

Үүний тулд сэтгэл хөдлөл, түүний орчуулгын тухай судалгааны ажил, онол, үзэл баримтлалуудыг судалж, Комиссар Мегрэ “Шар нохой” Жорж Сименон /Le commissaire Maigret “Le chien jaune” Georges Simenon/, Ги Дө Мопассаны “Шилдэг өгүүллэгүүд”-ийн монгол орчуулга, Г.Мэнд-Ооёо “Шөргөн шар ат”, Г.Чинаг “Эх” өгүүллэгүүдийн франц орчуулгад ажиглалт хийв.

Юуны өмнө сэтгэл хөдлөл гэж юу вэ, түүний онцлогийг авч үзье. Сэтгэл хөдлөлийг *Emereo* буюу *хачирхуулах, гайхуулах* гэсэн утгатай латин үгнээс гаралтай гэж үздэг бол англи хэлний Оксфордын толь бичигт *mouvoir* буюу *хөдлөх* гэсэн франц үгнээс гаралтай гэж тайлбарлажээ. Философичид, хүн судлаачид, сэтгэл судлаачид энэ ойлголтыг эртнээс судалж, танихуй болон нийгмийн харилцаанд гүйцэтгэж буй үүргийг нь тодорхойлсон байдаг. Сэтгэл хөдлөлийн талаарх эргэцүүлэл эртнээс эхэлсэн. Аристотель анх сэтгэл хөдлөлийг тодорхойлж, уур, өрөвч сэтгэл, айдас гэх мэтээр ангилан хуваажээ (Damasio, 1994: 74). Сүүлийн үеийн шинжлэх ухааны хөгжил, техник технологийн хөгжлийн

³⁵ Доктор /Ph.D./, МУИС, ШУС, ХУС-ын Европ судлалын тэнхим

ачаар сэтгэл хөдлөлийг илүү нарийвчлан судалж, хүний хандлага, төлөвшилд сэтгэл хөдлөл хэчнээн чухал болохыг туршилтын аргаар тодорхойлсон байна.

2005 онд Шерерийн (Scherer et al., 2004: 501) *Сэтгэл хөдлөлийн танихуйн онол*-оор сэтгэл хөдлөл бол тухайн хүн аливаа нэг нөхцөл байдлыг мэдэрч, түүнд хандаж буй хэв маяг буюу хүчтэй, богино хугацааны мэдрэмж гэж тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, нөхцөл байдал сэтгэл хөдлөлийг бий болгодоггүй, харин хүн бүрийн тухайн нөхцөл байдалд хандаж байгаа хариу үйлдэл юм. Эндээс нэг нөхцөл байдалд хүмүүсийн сэтгэл хөдлөл харилцан адилгүй байх боломжтой гэсэн дүгнэлт гарч байна. 1884 онд Жеймсийн “Сэтгэлийн хөдөлгөөн гэж юу вэ?” гэсэн бүтээл бичигдсэнээс хойш шинжлэх ухааны түвшинд судлагдаж эхэлсэн гэж үздэг (Christopher, D. 1913: 158). Д.Санжжав (1998: 120) сэтгэл гэдэг бол хүнээс өөртөө болон гадаад ертөнцөд хандах хандлагыг илэрхийлсэн ерөнхийлөн дүгнэгдсэн тогтвортой харьцаа буюу сэтгэлийн хөдөлгөөний нарийн шинж юм. Сэтгэл нь хүний амьдралын тодорхой нөхцөл, боловсрол, хүмүүжил, ажлын нөлөөгөөр үүсэж хөгждөг үзэгдэл юм.

Сэтгэл хөдлөлийг олон талаас судалж, ангиллуудыг хийсэн байдгаас жишээлэн дор хүснэгтэд оруулав.

Хүснэгт 1. Сэтгэл хөдлөлийг ангилах нь
(Magalie Ochs et al. 2006: 607-620)

Сэтгэл хөдлөлийн төрөл, онцлог	Нөлөөлөх хүч	Үргэлжлэх хугацаа	Давхцах	Тухайн үйл явдлыг анхаарах	Үнэлэмжид нөлөөлөх	Өөрчлөгдөх хурд	Хандлагад үзүүлэх нөлөө
Сэтгэл хөдлөл: уурлах, гуниглах, баярлах, ичих, бардамнах, дургүйцэх, цөхрөх	•	•	•	•	•	•	•
Төлөв байдал: сэргэлэн цовоо, бүүдгэр дүнсгэр, бухимдуу, сул дорой, сэтгэлээр унасан, хүчтэй	•	•	•	•	•	•	•
Хүмүүсийн харилцааны хандлага: алслагдмал, хүйтэн, дулаахан, дэмжсэн, дээрэнгүй	•	•	•	•	•	•	•
Сонголт/хандлага: дурлах, хайрлах, үзэн ядах, эрхэмлэх, хүсэх	•	•	•	•	•	•	•
Нөлөөлөлд өртөх: почирдох, түгших, анхааралгүй байх, гонсойх, өсөрхөх	•	•	•	•	•	•	•

Мөн Францын судлаач Ваннина Гуссенс (2005: 224) сэтгэл хөдлөлийг дөрөв ангилж, харгалзах үг хэллэгийг дараах байдлаар авч үзжээ.

1. Ямар нэгэн зүйлээс шалтгаалсан боловч түүн рүү чиглэгдээгүй: айх, санаа зовох, сандрах, баярлах, гуних, зовох, наргих, гиюүрэх, цочирдох, гайхах, түгших, тэмцэх
2. Ямар нэгэн зүйлээс шалтгаалаагүй ч тухайн зүйл рүү чиглэсэн: үзэн ядах, жигших, хардах, хайрлах
3. Ямар нэгэн зүйлээс шалтгаалсан ба түүн рүү чиглэсэн: ичих, эвгүйцэх, уурлах, агсрах, омогших, атаархах, хүндлэх, энэрэх
4. Ямар нэгэн зүйлээс үл шалтгаалсан ба ямар нэгэн объект рүү үл чиглэсэн: шаналах, цөхрөх, хулчийх, залхах, дүнсийх.

Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэг ба түүний ангилал

Сэтгэл хөдлөлийг илэрхийлэх үг хэллэгийг хамгийн өргөн агуулгаар тодорхойлж ангилж болно. Өөрөөр хэлбэл, сэтгэл хөдлөл илэрхийлж буй үндсэн (денотат), шилжсэн (коннотат) утгаар хэрэглэгдэж байгаа бүх үгийг хамруулж болно. Эдгээр үг хэллэгийг ангилах олон үзэл баримтлал, онол буй боловч үүнээс 2 онолыг онцлон дурдая. Ортони, Клор, Фосс (Ortony, Clore et Foss, 1987) нарын санал буюу загварыг олон эрдэмтэд орчуулгадаа баримталж байгаа юм. Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэгийг тодорхойлохын тулд тэд туршилтад оролцогчдод тодорхой үгсийг өгч, “мэдрэх”, “байх” хэмээх хоёр үгийн аль нэгтэй холбоо үг болгон хэрэглэх даалгавар өгчээ. Хоёр үгтэй хоёулантай хамт хэрэглэгдэж байгаа үг сэтгэл хөдлөлийг илэрхийлсэн үг байх магадлал хамгийн өндөр байсныг тэд олж харсан байна. Тухайлбал, “feeling joyful”, “being joyful” гэж хоёр холбоо үг үүсгэж байсан бол “ignored” гэдэг үгийн хувьд гагцхүү “feeling ignored” гэж холбоо үг үүсгэсэн байна. “ignored” гэдгийг “байх” гэдэг үгтэй хэрэглэвэл сэтгэл хөдлөл илэрхийлэхгүй гэж оролцогчид үзсэн байна. Судалгааныхаа үр дүнд тэд сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэгийг найман ангилалд хуваажээ: *биеийн илэрхийлэл, сэтгэлийн илэрхийлэл, сэтгэл-хандлагын байр байдал, сэтгэл хөдлөл-танихуйн байдал, хандлага-танихуйн хандлага, танихуйн хандлага, хувийн үнэлэмжийн илэрхийлэл ба бодит байдлын дүрслэл-илэрхийлэл*. Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэг гэж үзэх шалгуур бол *оюун санааны байдал, тэр дундаа сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөл-хандлага, сэтгэл хөдлөл-танихуйн* онцлог байдлыг илэрхийлсэн үг байх ёстой гэж үзжээ.

Үнэндээ сэтгэл хөдлөл гэдэг өөрөө төвөгтэй ойлголт тул түүнийг илэрхийлсэн үг хэллэгийн ангиллыг бүх хэлнээ гагц нэг загвараар хийх боломжгүй гэдгийг эрдэмтэд хүлээн зөвшөөрдөг билээ. Тиллер (Tiller, 1988), Жонсон Кэйт, Оатлэй (Johnson-Laird, P. N., and Keith Oatley, 1988) нар сэтгэл хөдлөлийг үгээр илэрхийлэхдээ ихэвчлэн тухайн сэтгэл хөдлөлтэй холбоотой туршлагаас үүдэн үгийн сонголт хийдэг гэж үзээд 590 үгийн жагсаалт гаргаж, тэдгээрийг аз жаргал, уйтгар гуниг, уур, айдас, дургүйцэл гэсэн таван үндсэн сэтгэл хөдлөлийн төлөвт ангилжээ.

Монгол, франц хэлээр сэтгэл хөдлөлийг илэрхийлэх нь

Энэхүү өгүүллэгийн хүрээнд баярлах, гуних утгыг илэрхийлэх онцлогийг тодотгон авч үзэв. Баярлах сэтгэл хөдлөл нь монголчуудын хувьд эрч хүч, баяр наадам, нулимс, гэрэл гэгээ гэсэн цогц ойлголтоор илэрдэг байна (Хун Ханий, 2015: 89). Жишээ нь:

- Эрч хүч: “Цээж дүүрэн баяр бялхаж байна.” (С. Дашдондов <Айлын хүүхэн Алгирмаа>), “Ай даа, энэ өдөр мөн амьдын жаргал дүүрэн байна” (Ш.Сүрэнжав, <Би тэнгэрийн харьяат>).
- Тайван амгалан: “Сайн нөхдөө цуглаж ирсэнд баярлаад санаа сэтгэлийн битүү бөглөө онгойгоод” (Д.Намдаг <Цаг төрийн үймээн>), Охин минь хүүхэд шиг хөөрч, ... сэтгэл хангалуун яваа бололтой. (Д.Мягмар <Цомирлогоо нээсэн цэцэг>)
- Хөнгөрч хөөрөх: “Сэтгэлд нэгэн баяр төрж, алдрайхан зүрх тэр л хэмээр булгилан цохилох бөлгөө” (Н.Лхагва <Толгодын цаана ингэ буйлна>), “Алаг зүрх минь баярлан догдлоо” (Б.Явуухулан <Хар ус нуурын шагшуурга>)
- Нулимстай холбоотой: “Цэнд гүйх гэснээ яг дороо зогсоход нүднээс нь баярын бүлээн нулимс өөрийн эрхгүй асгарав” (Ч.Лодойдамба <Тунгалаг тамир>)

Амьтай юм бүхэн хөдөлгөөнтэй. Баярлах утга илтгэх сэтгэл хөдлөл нь хүний дотоод сэтгэлийг хөдөлгөж утгын хувьд “догдлох, халуун дулаан, эрч хүчээр дүүрэн байх гэсэн” мэдрэмжтэй болгодог байна. Монгол эхэд хэрэглэсэн үг хэллэгийг ажиглахад “баяр бялхах, амьдын жаргалан дүүрэн, сэтгэл ... онгойгоод, ... хангалуун, булгилан зохилох, баярлан догдлох, нулимс асгарах” зэргээр дүүрэн, оргилсон, баярласан, уйлсан гэсэн үндсэн утга харагдаж байна.

Комиссар Мегрэ “Шар нохой” Жорж Сименон /Le commissaire Maigret “Le chien jaune” Georges Simenon/, Ги Дө Мопассаны “Шилдэг өгүүллэгүүд” бүтээлүүдээс франц хэлний жишээгээр баярлах сэтгэл хөдлөлийг хэрхэн илэрхийлж байгааг харья. Жишээ нь:

- Баяр наадам: C'est malheureux de ne pas avoir de piano parce qu'on pourrait pincer un quadrille - Даанч төгөлдөр баян хуур алга даа, тэрнээс биш бүжиглэцгээвэл аштай вэ? гэж Луаза хэлэв
- Биеийн хэлэмж: Je collabore, pour m'amuser, au Phare de Brest... Il sautillait, gesticulait- Тэгээд зүгээр байхын оронд зугаа болгож “Фар де Брест”-д ажиллаж байна... гэснээ хөл нь хөнгөрөн, гараа савчин сунгаснаа
- Нулимстай холбоотой: Le capitaine d'Anglemare riait aux larmes en me disant l'histoire, Ахмад д'Англемар - Энэ явдлыг яриад, нулимсаа дуслуулан элгээ хөштөл хөштөл инээж билээ.
- Хайр халамж: Mais Simon sauta au cou de sa mère et lui dit en se remettant à pleurer, Гэтэл Симон ээжийнхээ хүзүүгээр тэвэрч дахин уйлж гарлаа.

- Дуу чимээ: Chacun était devenu subitement communicatif et bruyant; une joie égrillarde emplissait les coeurs, Гэнэт цөмөөрөө яриа хөөрөөтэй, шуугиантай хөгжөөнтэй болж, сэтгэл машид сэргэцгээв
- Гэрэл гэгээ: Aussitôt un grand soupir de soulagement sortit de toutes les poitrines, une allégresse parut sur les visages, Гэтэл тэд дорхноо сэтгэл амран сүүрс алдацгааж, царай зүс ч орлоо

Түүвэрлэсэн өгүүлбэрүүдээс харахад баяр хөөрийг илэрхийлэхдээ франц хүний хувьд бүжиг наадам, хайр халамж, нулимс, өнгө зүс орох, гэрэл гэгээ, чанга дуу алдах хэмээх үгсийг сонгожээ.

Эндээс харахад, баярлах сэтгэл хөдлөлийг монгол, франц хүмүүс ялгаатай хандлага, байдлаар илэрхийлж, үүнийгээ дагаад хэрэглэх үг хэллэг нь ялгарч байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, франц, монгол хүмүүсийн сэтгэл хөдлөлөө илэрхийлэх онцлог ерөнхий сэтгэл судлалын түгээмэл онолын хувьд ижил төстэй мэт боловч, давтамж, илэрхийлэл, үг хэллэгийн хувьд ялгаатай байна.

Хүний сэтгэл хөдлөл улс үндэстэн, үе удмаас үл хамааран хүн бүрт байх мөртөө тэдгээрийг танин, ойлгож, илэрхийлэх арга нь улс үндэстэн бүрд өөр байдаг. Энэ нь тухайн үндэстний түүх соёл, сэтгэлгээ, ард түмний аж ахуйн онцлог, цаг агаар, амьдралын хэвшил зэргээс үүдэлтэй байж болно.

Сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг хэллэгийг орчуулах тухайд

Сэтгэл хөдлөлийг авиа зүй, авиалбарзүй, өгүүлбэр зүй, утга зүй, нийгэм хэл шинжлэл, прагматик зэрэг хэл шинжлэлийн бүхий л түвшинд судалсан байдаг. Хэдий сэтгэл хөдлөл нь хэл шинжлэлийн судлагдахуун бус ч сэтгэл хөдлөлийг илэрхийлэх гол хэрэгсэл бол хэл юм.

Нөгөөтэйгүүр, сэтгэл хөдлөлийн цаана тухайн ард түмний соёл, нийгмийн онцлог нягт шингэсэн байдаг тул хэлээр түүнийг илэрхийлэх, орчуулах ярвигтай ажил юм. Энэ нь нэг ард түмний сэтгэл хөдлөл илэрхийлсэн үг өөр ард түмнийхээс тэс ондоо буюу дүйцэлгүй байх, бүрэн бус дүйцэх тохиолдол элбэг байдагтай холбоотой. Сэтгэл хөдлөлийг хоёр өөр хэл соёлын үүднээс авч үзэх нь тэр хэмжээгээр нарийн төвөгтэй цогц ойлголт юм. Тиймээс хэл, соёл, сэтгэл хөдлөл хоорондоо салшгүй холбоотой тул энэ талаас судалсан судалгаа цөөнгүй бий. Ер нь сэтгэл хөдлөлийг хэл шинжлэлийн үүднээс судалснаас хойш хорь гаруйхан жил болж байна. Соёл хоорондын харилцааг шинжилсэн хэл шинжлэл, антропологи, сэтгэл судлалын судалгаанууд орчуулгын асуудал руу холбогдож, орчуулгын дүйцэл, соёлын ялгаа гэдэг ойлголттой холбогддог. Тухайлбал, Шерерийн (Scherer, 2005) сэтгэл хөдлөлийг олон хэл соёлын үүднээс судалсны эцэст, сэтгэл хөдлөлтэй холбогдох үг хэллэг олон хэлээр нэг ойлголттой байх шаардлагатай гэж үзээд англи хэлээр боловсруулсан үг хэллэгийг герман, франц, итали, испани хэлээр орчуулсан байна. Гэвч Шерер энэхүү жагсаалтаа бол бүрэн бус, үг хэллэгийн дүйцлийг эргэн нягтлууштай, цаашид дэлгэрүүлэн хийх эхлэл болохыг онцолсон байдаг. Ж.Баянсан (2002) монгол хэлний тогтвортой хэллэгт монгол сэтгэлгээний онцлог хэрхэн тусч илэрсэн байгааг судлан шинжилсэн

ажлынхаа зарим үр дүнгээс нийтлүүлж хэвлэн гаргасан бөгөөд 2016 онд “Соёл, хэл, үндэстний сэтгэлгээ” судалгааны ном гаргав. С.Долгор (2013) япон, монгол хэлний дуурайх үгийн жишээгээр тус тусын онцлог шинжийг танихуйн хэл шинжлэл, хэл соёлын үүднээс тайлбарласан “Япон, Монгол хэлний дуурайх үгийн харьцуулалт” өгүүлэл бичив. Б.Пүрэв-Очир (2013) монгол хэлэнд мал, амьтантай холбоотойгоор үүссэн хэвшмэл хэллэг, метафор буюу зүйрлэлийн тухай судалбар эсээ бичсэн. Инь-Хуа Ханий (2017) “Монгол, Солонгос хэлэнд сэтгэл хөдлөлийг илэрхийлэх онцлог, танихуйн утга” Хэл бичгийн ухааны докторын (Ph.D)-ын зэрэг горилсон диссертаци, 2019 онд Н.Нансалмаа “Нийгэм хэл шинжлэл” номдоо хэл, соёлын нарийн нягт шүтэлцээг нийгэм хэл шинжлэлийн үүднээс нарийвчлан авч үзсэн бүтээл гаргажээ.

Уран зохиолд нэн тэргүүнд тухайн сэтгэл хөдлөлийг шууд илтгэх үйл үг, жинхэнэ нэр, тэмдэг нэр гэх мэт үгүүд байх хэрэглэгдэнэ. Тухайлбал, гунигтай буйг илэрхийлэх хамгийн түгээмэл үг бол уйлах байхад, баяртай буйг илтгэх нь инээх бөгөөд энэ үгнээсээ улбаалсан хэлний бусад хэллэгүүд бий болдог байна.

Бидний түүвэрлэсэн өгүүлбэрүүд дунд, éclater de rire /хөхрөх/, sourire /инээх/, un tressaillement de joie /баярлах/, remercier /талархах/, tout à coup se tordre /гэнэт инээх/, s’amuser /хөгжилдөх/, navrer /гүн гунигт автах/, s’inquiéter /санаа зовох/, pleurer /уйлах/, tristesse /гуниг/, des larmes /нулимс/, sangloter/цурхиран уйлах/, une solitude /ганцаардал/, souffrir /зовох/, la douleur /өвдөлт/, torturant /шаналгаат/ гэх мэт үгсээр дүрүүдийн баярлах, гунихыг илэрхийлсэн шууд үгсийг хэрэглэжээ. Мөн түүнчлэн үүнээс гадна, баярыг илэрхийлэх баярлах, хөгжилтэй, бахдал, горьдлого, хөөрөл, догдлол, жаргал, санаа амрах, сэтгэл хөөрөх, сэтгэл онгойх, тааламжтай байх, тайван, талархал, гунигийг илтгэх гашуудал, гонсойх, гуниг, ганцаардал, цөхрөл, шаналал, урам хугарах, тоомжиргүй байх гэх мэт үгс байх боломжтой.

Франц хэлнээ гуниг, баярыг илтгэх дараах тэмдэг нэрүүд байна.³⁶

Хүснэгт 2. Франц хэлнээ гуниг, баярыг илтгэх тэмдэг нэрс

№	Гуниг/ франц	Монгол орчуулга	Баяр /франц/	Монгол орчуулга
1	Abattu	Хожигдсон, ялагдсан	Affectueux	Элгэмсэг, эелдэг
2	Affligé	Эмгэнэлтэй, гашуудалтай	Agréable	Сайхан, таатай
3	Apathique	Хайхрамжгүй, үл тоосон	Allègre	Хөгжүүн, цогтой
4	Blessé	Шархдсан, гэмтсэн	Amical	Нөхөрсөг
5	Bouleversé	Орвонгоороо эргэсэн	Amusé	Зугаатай, хөгжилтэй
6	Cafardeux	Уйтгартай	Bon	Сайн, зөв
8	Chagriné	Гутарсан, гомдсон	Chaleureux	Халуун, дулаан
9	Découragé	Шантарсан, цөхөрсөн	Chanceux	Хувьтай, завшаантай
10	Déçu	Урам хугарсан	Comblé	Сэтгэл хөөрсөн, дүүрсэн
11	Dégoûté	Онцгүй, балиар	Confortable	Тухтай, аятай
12	Déprimé	Сэтгэлээр унасан	Content	Сэтгэл хангалуун
13	Désespéré	Найдваргүй, гонсойсон	Décontracté	Тайван, чөлөөтэй

³⁶ <https://www.seliberer.fr/le-vocabulaire-des-emotions-et-sentiments/> /accessed 14:27, may 3, 2019/

14	Embarrassé	Сандарсан, тэвдсэн	Enchanté	Сэтгэл татам, гайхшруулам
15	Ennuyé	Уйтгартай	Entrain (plein d')	Мэргэших, дасгалжи
16	Éteint	Муу, муудсан	Enthousiaste	Урам зориг, бахдалта
17	Fatigué	Ядарсан	Euphorique	Сэтгэл сэргээм
18	Honteux	Ичсэн	Exubérant	Хангалуун
19	Humilié	Доромжилсон	Fier	Бахархам
20	Inadéquat	Хангалтгүй, үл нийцсэн	Forme	Эрч хүчтэй
21	Inintéressant	Сонирхолгүй	Gai	Сэргэлэн, хөхүүн хөгжилтэй
22	Isolé	Алслагдсан, тусгаарлагдсан	Harmonieux	Эв найрамдалтай
23	Lugubre	Дүнсгэр, бүрхэг	Heureux	Аз жаргалтай
24	Malheureux	Азгүй, харамсалтай	Jovial	Сайхан зантай, баясгалантай
25	Meurtri	Шархдах	Joyeux	Азтай, хөөрч догдолсон
26	Nostalgique	Мөрөөдсөн, гунисан	Libre	Эрх чөлөөтэй
27	Navré	Гутарсан, эмтэрсэн	Lumineux	Гэрэл гэгээтэй
28	Raumé	Шуналтай	Motivé	Дуу шуутай, урам зориг дүүрэн
29	Pessimiste	Гутранги үзэлтэй	Nourri	Өег, цагалан
30	Prostré	Хүчгүйдсэн	Optimiste	Өөдрөг
31	Résigné	Хүлцэнгүй	Passionné	Хүсэл тэмүүлэлтэй
32	Submergé	Живсэн	Ravi	Баяртай
33	Tourmenté	Зовлонт	Reconnaissant	Талархалтай
34	Triste	Гунигтай	Satisfait	Сэтгэл хангалуун
35	Vaincu	Ялагдсан, сүйрсэн	Stimulé	Урамшсан, сэргэсэн
36	Vidé	Хоосон	Transporté	Догдолсон, хөөрсөн

Ерөнхий хэл шинжлэлд фразеологизм, (герег хэлний phrasis- илэрхийлэх, хэллэг, logia- нэгдмэл, эмхтгэл гэснээс үүдэлтэй латин хэлний phrasologia, анх 1558 онд тэмдэглэгдсэн) ба идиом гэх хоёр нэр томъёо зэрэгцэн оршиж ирсэн байна. Хэл шинжлэлд энэхүү нэр томъёог хэлний хэлц үгийн судалбар салбар гэсэн утгаар хэрэглэдэг. Идиом, (idios- ер бусын, онцгой гэсэн утгатай герег хэлний үг) нэр томъёо анх 1578 онд Оксфорд толь бичигт тэмдэглэгджээ. Ш.Балли хэлц үг судлалд онцгой хувь нэмэр оруулсан ба тэрээр ердийн холбоо үгээс өвөрмөц хэлцийг ялгаж үзэх санал болгож анхны ангиллыг хийжээ (Н.Нансалмаа, 2015: 156).

Монгол хэлний тайлбар толь-д хэлц үгийг тухайн хэллэгт орсон үгс тус тусынхаа үндсэн утгаа алдаж, хоорондоо нийлж нэгэн утга санаа илэрхийлэх тогтвортой үг хэмээн тодорхойлжээ. “Орчин цагийн монгол хэл (2004:368)”-д “Хэлц нь үгээс өргөн, агуулга хэлбэр, бүтэц бүрэлдүүлбэр, илэрхийлэх утга, мэдээлэл дамжуулахын хувьд өгүүлбэртэй адил талаар эхийн түвшинд

судлагдахаар өргөн агуулгатай болно. Хэлц нь тухайн ард түмний сэтгэлгээ, ёс заншил, түүх зэрэг үндэсний онцлогийг хадгалж байдаг. Хэлцийн олонх нь шилжмэл утгатай бөгөөд хүний санаа, сэтгэлийн хөдөлгөөн, найруулгын олон өнгө аясыг илтгэсэн, юмс үзэгдлийг шууд ба шууд бусаар заан нэрлэсэн байдаг” гэжээ. Хэдий хэлц өргөн хүрээтэй сэдэв боловч ажиглах явцад гарсан хэлц үгээр илэрсэн сэтгэл хөдлөлүүдийг танихуйн түвшинд гүнзгийрүүлэлгүй, үгийн сангийн түвшинд авч үзсэн болно. Ажиглалтын явцад, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх хэлц үг цөөнгүй гарсан. Дурдвал:

- “Il sautillait- хөл нь хөнгөрөн” буюу франц эхнээ үсрэх гэсэн үйл үгийг монгол хэлэнд хөл нь хөнгөрөн буюу - баяр хөөр болж, сэтгэл нь хөдлөх гэсэн утга бүхий хэлц үгээр илэрхийлсэн байна.
- “L’agent était flatté- хөл нь газар хүрэхгүй” буюу франц эх дээр өөрөөрөө бахархах гэсэн утга бүхий үгийг хэт их баярлах гэсэн утга бүхий хэлцээр орчуулсан байна.
- “Rire aux larmes- элгээ хөштөл инээх” нулимстай инээх гэсэн хэллэгийг ихэд хөгжин удаан инээх хэмээх утгатай хэлцээр дүйцүүлжээ.
- “Rire jaune, тамираа тасартал инээх” хүчилж инээх гэсэн утга бүхий франц хэлцийг монгол хэлний тамираа тасартал инээх гэсэн хэллэгээр буулгажээ.

Франц, монгол хэлнээ сэтгэл хөдлөлийг, тэр дундаа баяр гунигийг илтгэх хэлцүүд цөөнгүй байна. Хэлц үгийн хүрээ маш өргөн боловч дараах хүснэгтүүдэд баяр ба гунигийг илтгэх цөөн тооны монгол, франц хэлц үгийг оруулав.

Ерөнхий хэл шинжлэлд фразеологизм, (герег хэлний phrasis- илэрхийлэх, хэллэг, logia- цуглуулга, эмхэтгэл гэснээс үүдэлтэй латин хэлний phraselogia, анх 1558 онд тэмдэглэгдсэн) ба идиом гэх хоёр нэр томъёо зэрэгцэн оршиж ирсэн байна. Хэл шинжлэлд энэхүү нэр томъёог хэлний хэлц үгийн судалбар салбар гэсэн утгаар хэрэглэдэг. Идиом, (idios- ер бусын, онцгой гэсэн утгатай герег хэлний үг) нэр томъёо анх 1578 онд Оксфорд толь бичигт тэмдэглэгджээ.

Монгол хэлний тайлбар толь-д хэлц үгийг тухайн хэллэгт орсон үгс тус тусынхаа үндсэн утгаа алдаж, хоорондоо нийлж нэгэн утга санаа илэрхийлэх тогтвортой үг хэмээн тодорхойлжээ.

Орчин цагийн монгол хэлний сурах бичгүүдэд тодорхойлохдоо хэлц нь үгээс өргөн, агуулга хэлбэр, бүтэц бүрэлдүүлбэр, илэрхийлэх утга, мэдээлэл дамжуулахын хувьд өгүүлбэртэй адил талаар эхийн түвшинд судлагдахаар өргөн агуулгатай болно гэжээ. Хэлц нь тухайн ард түмний сэтгэлгээ, ёс заншил, түүх зэрэг үндэсний онцлогийг хадгалж байдаг. Хэлцийн олонх нь шилжмэл утгатай бөгөөд хүний санаа, сэтгэлийн хөдөлгөөн, найруулгын олон өнгө аясыг илтгэсэн, юмс үзэгдлийг шууд ба шууд бусаар заан нэрлэсэн байдаг. Хэдий хэлц өргөн хүрээтэй сэдэв боловч ажиглах явцад гарсан хэлц үгээр илэрсэн сэтгэл хөдлөлүүдийг танихуйн түвшинд гүнзгийрүүлэлгүй, үгийн сангийн түвшинд авч үзсэн болно. Ажиглалтын явцад, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх хэлц үг цөөнгүй гарсан. Дурдвал:

- “Il sautillait- хөл нь хөнгөрөн” буюу франц эхэд *үсчих* (үгч.) гэсэн үйл үгийг монгол хэлэнд *хөл нь хөнгөрөн* буюу баяр хөөр болж, сэтгэл нь хөдлөх гэсэн утга бүхий хэлц үгээр илэрхийлсэн байна.
- “L’agent était flatté- хөл нь газар хүрэхгүй” буюу франц эх дээр *өөрөөрөө бахархах* (үгч.) гэсэн утга бүхий үгийг хэт их баярлах гэсэн утга бүхий хэлцээр орчуулсан байна.
- “Rire aux larmes- элгээ хөштөл инээх” *нулимстай инээх* (үгч.) гэсэн хэллэгийг ихэд хөгжин удаан инээх хэмээх утгатай хэлцээр дүйцүүлжээ.
- “Rire jaune - тамираа тасартал инээх” *шар инээх* (үгч.) гэсэн утга бүхий франц хэлцийг монгол хэлний тамираа тасартал инээх гэсэн хэллэгээр буулгажээ.

Франц, монгол хэлнээ сэтгэл хөдлөлийг, тэр дундаа баяр, гунигийг илтгэх хэлцүүд цөөнгүй байна. Хэлц үгийн хүрээ маш өргөн боловч дараах хүснэгтүүдэд баяр ба гунигийг илтгэх цөөн тооны монгол, франц хэлц үгийг оруулав.

Хүснэгт 3. Баяр, гунигийг илтгэх монгол хэлцүүд (Сүлд-Эрдэнэ ба бусад, 2018)

№	Гунигийг илтгэх хэлц	Тайлбар	Баярыг илтгэх хэлц	Тайлбар
1	Арьс махтай нь хатаах	Зовоох, сэтгэлийн там эдлүүлж, шаналгах	Баярын нар нь гарах	Баярлах, баярт учрал тохиох
2	Ацан шалаан орох	Мухардах, гарах гарцгүй болох, арга тасрах	Баярласан хэрэг бархирах	Баярлаж бархирах, баярхах
3	Бэтэг хагарах	Хүсэн хүлээж, шаналан зовж байсан сэтгэл амрах	Голыг нь дэвтээх	Сэтгэлийг амрах, тайвшруулах
4	Гандирсан балгас мэт болох	Хий хоосон зүйл болох, цэнэгүй болох	Гуяа алгадах	Тэсгэлгүй их баярлах
5	Гол гонсойх	Сэтгэл дундуур болох, гомдох	Дүштийн оронд гарах	Хязгааргүй баярлах
6	Гол нь харлах	Харамсах, гомдох	Зүрх булгилах	Баяр бахдал төрөх, сэтгэл ихэд хөвөлзөх
7	Дотор буцлах	Үнэн голоосоо үзэн ядах, дургүй нь хүрэх	Инээд ханиад болох	Хөөрөн найрч, наргиан дэвжээн болох
8	Дотор харанхуйлах	Сэтгэл ихэд шаналан балрах	Магнай тэнийх	Сэтгэл баясаж, дотор их уужрах
9	Зүрх пал хийх	Цочирдож, сэтгэл тавгүйрхэх	Магнай хагарах	Баяр бахдал их байж өөрийн сэтгэлд багтаж ядах
10	Зүрх эмтрэх	Сэтгэл өвдөх, шаналах	Нуруу тэнийх	Зовлон зүдгүүрээс ангижрах, амрах
11	Нулимсаараа нүүрээ угаах	Маш их зовох, зүдрэх	Нүд гийх	Цээж саруул болох, аятай болох, дотор онгойх
12	Өнчин элгээ эмтлэх	Зүрх шимшрэх, тэсгэлгүй өр өвдөн хайрлах	Одтой төрөх	Аз жаргалтай, хийморьтой

13	Хал амсах	Зовлон зүдгүүр эдлэх	Тэнгэр үзэх	Азтай
14	Тогоо нэрэх	Их уйлах	Хөл хөнгөрөх	Баяр хөөр болж сэтгэл нь хөөрөх
15	Царай алдах	Шаналах, зовох	Хөх инээд хүрэх	Тавлах, басамжлах
16	Цээж дүүрэх	Сэтгэл санаа их зовох, шаналах	Цээж дүүрэн	Сэтгэл санаагаар өөдрөг байх
17	Цээжний махаа барах	Сэтгэл санаа зовж, шаналах	Цээж дэвтэх	Сэтгэл онгойх, тайвшрах
18	Элгээ эмтрүүлэх	Янз бүрийн юм үзэж харж, бодон сэтгэлээ эмзэглүүлэх	Цээж тэнийх	Сэтгэлийн зовлон, дарамт арилах
19	Элэг зүрх өмрөх	Сэтгэл санаа зовж, ихэд шаналах	Элэг дэвтэх	Энэлж шаналсан сэтгэл тайвшрах
20	Элэг хатаах	Зовох, шанлах, үйлийг нь үзэх	Элэг хөших	Хэтэрхий инээх, инээдээ барьж ядах

Хүснэгт 4. Баяр, гунигийг илтгэх франц хэлцүүд

№	Баярыг илтгэх хэлц /франц/	Үгчилсэн монгол орчуулга	Гунигийг илтгэх хэлц /франц/	Үгчилсэн монгол орчуулга
1	Après la pluie, le beau temps	Борооны дараа, нар гарна	Avoir la gorge serrée	Хоолой нь бачуурах
2	Avoir la joie au coeur	Зүрхэндээ баяртай байх	Avoir la mort dans l'âme	Сүнс нь үхчихсэн байх
3	Avoir un bonheur exotique	Хачин жаргалтай байх	Avoir la vague à l'âme	Оюун ухаандаа давлагаатай байх
4	avoir une face joyeuse	Жаргалтай царайтай байх	Avoir le coeur noir	Хар зүрхтэй байх
5	Baigner dans l'allégresse	Баяр баясгаландаа умбах	Avoir un regard douloureux	Шаналгаатай харагдах
6	Etre à fond des ballons	Бөмбөлөг дунд байх	Avoir une figure morne	Бараан царайлах
7	Etre au paradis	Диваажинд байх	Avoir une tête d'enterrement	Оршуулагдах гэж буй мэт царайлах
8	Etre gai comme un pinson	Болжмор шувуу шиг хөгжүүн байх	Baigner dans la tristesse	Гунигт живэх
9	Etre rempli de joie	Аз жаргалаар дүүрэх	Broyer du noir	Хар бараанд автагдах
10	Etre au comble de la joie	Аз жаргалын оргилд байх	Devenir pâle comme un mort	Үхсэн хүн шиг цонхийх
11	Etre aux anges	Сахиусан тэнгэрт байх	Etre cafard	Жоом байх
12	Pleurer de joie	Баярлаж уйлах	Etre déplorable	Хөөрхийлөлтэй байх
13	La vie me sourit	Амьдрал өөдөөс инээх	Être malheureux comme les pierres	Чулуу шиг азгүй байх
14	Etre au septième ciel	Долоо дахь тэнгэрт байх	Etre maussade	Үглээ, яншаа байх
15	Etre en liesse	Баяр хөөртэй байх	Etre morose	Хөшсөн мэт байх
16	Heureux comme un	Агаарт байгаа шувуу шиг	Perdre le goût de vivre	Амьдрал хүслээ алдах

	oiseau dans l'air			
17	Larmes de joie	Баярын нулимс	Pleurer comme un madeleine	Маделейн шиг уйлах
18	Sourire jusqu'aux oreilles	Чихээ хүртэл инээх	Triste comme le c noir	Бүрхэг тэнгэр шиг бүүдийх
19	Heureux comme un poisson dans l'eau	Усан дотор байгаа загас шиг	Triste comme un bonnet de nuit	Унтлагын малгай шиг гунигтай
20	Sauter de joie	Баярлан үсрэх	Une profonde amertume m' envahit	Маш гүн гуниглалд автах

Харин франц хэлэнд харанхуй, цөхрөл, уйлах гэсэн ойлголтоор илэрхийлж болно гэж үзэж байна. Францууд сэтгэл хөдлөлөө өнгөөр илэрхийлэх тохиолдол цөөнгүй ба гунигийг хар өнгө болон харанхуйгаар, баяр хөөрийг цагаан, шар өнгөөр илэрхийлдэг байна. Мөн цөхөрсөн, давчидсан, гарцгүй болсон гэсэн санаагаар илэрхийлсэн тохиолдол нилээдгүй байна.

Сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд яруу хэрэглүүр чухал үүрэгтэй. Өгүүлж байгаа зүйлийг уран дүрслэлтэй болгохын тулд үгийн утгыг шилжүүлэн дүрслэхийг утга шилжүүлэх яруу хэрэглүүр гэнэ. Яруу хэрэглүүрүүд яриаг чимэгтэй, сонсголонтой, сонирхолтой болгоход нэг чухал үүрэгтэй. Үүнийг дүрслэх ур маяг ч гэдэг. М.Базаррагчаа: “Үгийн утга адилтгал ба зүйрлэл, орлол ба төлөөлөл, ихэсгэл ба багасгал, ёгтлол ба егөөдөл, бэлгэдэл ба цээрлэл зэргээр салаалахыг дүрслэх ур маяг гэнэ.” Яруу хэрэглүүрийг адилтгал, төлөөлөл, чимэг үг, зүйрлэл, орлуулал, тойруулал, амьдчилал, бэлгэдэл, ёгтлол, гм ангилна.

Жишээ нь

Г.Мэнд-Ооёо, “Шөргөн шар ат” өгүүллэгийн франц орчуулгын хэсгээс үзье.

- (1). Таана гишгэлэн гувалзтал алхахыг харвал тавхайдаа хилэн хар үстэй түүний таван гүвээ даваад бөмбөлзүүлж ирэх нь тэнгэрийн унаа мэт, зогдор сэвлэг нь далавч адил дэвэлзэн, дээр нь унахад нисдэг хивсэн дээр суусан мэт дэнслэх донслохын учир гэж үгүй.

Avec sa démarche bondissante, ses crins duveteux flottant comme des ailes et ses sabots aux poils noirs foulant les poireaux sauvages, on eût dit une monture céleste. Et lorsqu'on le montait, on ne ressentait aucun rebond, comme si l'on roulait sur un tapis volant parfaitement imperturbable.

- (2) Орь ганцаар хүний нутаг дээр үлдсэн хөөрхий Шөргөн шар ат арайхийн өндийж сөхрөн хэвтээд эх нутгийнхаа зүг мэлмэн хар нүднээсээ нулимс бөмбөрүүлэн хэсэг харж байснаа хормын төдий ч амсхийлгүй мөлхөж гарлаа.

Il était couché, à peine capable de se lever sur ses genoux. Il tourna ses yeux noirs remplis de larmes et regarda un moment en direction de sa patrie. Il se mit à ramper sans relâche.

- (3) Бие нь сульдах тусам орчлон дэлхийн өнгөний жавхлан улам улам сулдайна.
Plus sa santé se détériorait, plus il lui semblait que le paysage perdait de sa vivacité.

Зүйрлэл: Юмс үзэгдлийн аль нэг шинжийг ялгаруулан тод томруун болгож, тодорхой төсөөлөл төрүүлэх зорилгоор өөр төстэй юм үзэгдэлтэй нь зэрэгцүүлэн тавьж дүрслэх найруулгын ур маягийг зүйрлэл гэнэ. Адилтгал: Юм үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр юм юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн дүрслэх найруулгын ур маягийг адилтгал гэнэ. Адилтгал бол далд зүйрлэл юм.

Жишээ:

Г.Чинаг, “Эх” өгүүллэгийн франц орчуулга

- (4) Дождид эмнэлгийн хаалганы хүйтэн төмөр бариулд гар хүрэхдээ агзасхийтэл жихүүцэн, бас л ийм хатуу, цэвдэг үг дуулах байх даа гэж зүрх алдан бодсон нь оносонгүй
Une fois arrivée devant la chambre d'hôpital, en saisissant la poignée glaciale de la porte, elle tressaillit, tremblant de tout son corps de peur d'entendre des mots tout aussi froids.

- (5) Шөнө дунд өнгөрөхийн хирд арслангийн ам шиг ангайсан харанхуйгаас нэг шувуу муухай дуугарахад хамаг бие нь хүйт даагаад явчихав.
Après minuit, il lui sembla que l'obscurité était comme la gueule grande-ouverte d'un lion. Tout à coup, un oiseau sortit des ténèbres. Au cri de ce dernier, un frisson lui parcourut tout le corps.

Хэтрүүлэл буюу ихэсгэл, багасгал, егөөдөл, ёгтлол, амьдчилал буюу хүнчлэл, хүншүүлэл, түүнчлэн авиа, дүрс дуурайх үгс зэрэг уран зохиолын олон арга замаар сэтгэл хөдлөлийг бий болгож болно. Энэ бүгдийг нэг өгүүллийн хэмжээнд бүгдийг авч үзэх боломжгүй байсан тул түр хойш тавилаа.

Дүгнэлт

Франц хэлэнд сэтгэл хөдлөлийг дан үгээр (үйл үг, нэр үг, тэмдэг нэр) түлхүү илэрхийлж байна. Хоёр хэл хэв шинжийн хувьд ялгаатай учир сэтгэл хөдлөл илэрхийлсэн үгс бүрэн дүйцэх нь цөөн ажээ. Тухайлбал, нэр үг үйл үгээр, эс бөгөөс эсрэгээрээ буужээ. Монгол эхийн нийлмэл урт өгүүлбэрийг 2-3 богино энгийн өгүүлбэр болгож буулгах тохиолдол элбэг байна.

Франц өгүүлбэрт *pleurer* (уйлах) гэсэн байхад *цурхиртал уйлав*, мөн *rire* (инээх) гэсэн байхад *элгээ хөштөл инээв* гэж буулгасан нь орчуулагчийн арга барил, мөн монгол хэлний үйл давамгайлсан, түнийгээ дагаад үйлийн тодотгол гишүүн түгээмэл хэрэглэдэг онцлог харагдаж байна.

Эцэст нь дүгнэхэд, соёл, сэтгэхүй, хоёр хэлний хэв шинжийн онцлогоос үүдэн сэтгэл хөдлөл илэрхийлэх үгийн сан явц цав таарахгүй тул орчуулахдаа үгийг чухалчилгүй утгыг баримтлан, сэтгэл хөдлөл мэдрэмжийг хэрхэн буулгах тал дээр илүү анхаарч, хоёр хэл ба соёлын онцлогийг харгалзан орчуулах нь нэн чухал юм.

Ном зүй

Монгол хэлээр:

1. Бямбадорж Б. (2014) “Монгол хэлний найруулга зүй”, УБ хот.
2. Ганбаяр Г. (2002) Уран зохиолын лекц, УБ хот.
3. Мөнхзул А. (2002) Авиа дуурайх үг”, МУИС-ийн магистрын зэрэг горилсон дипломын ажил, УБ
4. Нансалмаа Н. (2015) Үгийн сан судлал, УБ хот.
5. Н.Нансалмаа Н. (2019) Нийгэм хэл шинжлэл, УБ хот.
6. Санжжав Д. (1998) Сэтгэл судлал, УБ хот.
7. Сүлд-Эрдэнэ Г., Уянга Б., Нямаа Д., Баасанбат Д., Баярсайхан Б., (2018) Монгол хэлний өвөрмөц хэлцийн толь, УБ хот.
8. Сүхбаатар Ц. (2013) Найруулга зүй, УБ хот.
9. Хуа Ханий. (2017) Монгол, Солонгос хэлэнд сэтгэл хөдлөлийг илэрхийлэх онцлог, танихуйн утга. Хэл бичгийн ухааны докторын (Ph.D)-ын зэрэг горилсон диссертаци, УБ хот.

Гадаад хэлээр:

1. Christopher. D., Green. (1913) *Classics in the History of Psychology*, “Psychological Review”, 20, 158-177.
2. Damasio A. (1994) *L’erreur de Descartes*, Paris.
3. James Southworth, William James (2014) *Theory Of Emotion*, The Western University, Graduate and Postdoctoral.
4. Nizha Chatar-Moumni, *L’expression verbale des emotions*, Paris.
5. Vannina Goossens (2005) *Les noms de sentiment*, Université Grenoble Alpes.
6. Johnson-Laird, P. N., and Keith Oatley. *The Language of Emotions: An Analysis of a Semantic Field*, “Cognition & Emotion” 3, no. 2 (1989): 107-122.
7. Magalie Ochs, Radoslaw Niewiadomski, Catherine Pelachaud, David Sadek, *Expressions Intelligentes des Emotions*, “Revue d’intelligence artificielle” 2006, 20(4): 607-620.
8. Ortony, Andrew, Gerald L. Clore, and Mark A. Foss. *The Referential Structure of the Affective Lexicon* “Cognitive Science” 11 (1987): 341-64.
9. Scherer, Klaus. R. *What Are Emotions? And How Can They Be Measured?* “Social Science Information” 44, no. 4 (2005): 695-729.
10. Scherer K.R., Wrang T., Sangsue J., Tran. *Emotions in everyday life: Probability of occurrence, risk factors, appraisal and reaction patterns*, “Social Science information Studies”, The University of Western Ontario London, Ontario, Canada, 2004, vol. 43, no. 4, p. 499-570
11. Tiller, D.K. (1988) *Structure in the Affective Lexicon*. D. Phil. Thesis, University of Oxford,